



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/09-НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2023 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Т.Мөнхзул Утас: 70362442 Цахим хаяг: munkhzult@audit.gov.mn</p> |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын дүгнэлт | 4 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 6 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга | 11 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 11 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 13 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 13 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 19 |
| 4. Аудитын тайлан | 22 |
| 4.1 Ерөнхий зүйл | 22 |
| 4.2 Материаллаг байдал | 22 |
| 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 23 |
| 4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 25 |
| 4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 26 |
| 5. Аудитын илрүүлэлт | 27 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | 31 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-------------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БОАЖГ | Байгаль, орчин аялал жуулчлалын газар |
| БОАЖЯ | Байгаль, орчин аялал жуулчлалын яам |
| ГХУССЗ | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| МУЗЗНДНТУ | Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |



Г ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Т
П.БАТБААТАР ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.25 № 107-2023/09-НА-СТА-ТТЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхонтуул сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 213,112.0 мянган төгрөгийн татварын орлого, 25,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 238,112.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 446,179.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 87.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 80.7 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 19.3 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Орхонтуул сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 30.7 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 30.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 30.8 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

| Код | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|--------|--|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 931,031.0 | 940,646.7 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 490,997.7 | 806,826.8 |
| 33 | АВЛАГА | 200,569.7 | 105,040.6 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 239,463.5 | 28,779.3 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 6,495,663.8 | 2,409,224.4 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 6,495,663.8 | 2,409,224.4 |
| 39200 | Биет хөрөнгө | 6,349,715.9 | 2,402,345.7 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 145,947.9 | 6,878.7 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 7,426,694.7 | 3,349,871.1 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 57,877.4 | 45,665.0 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 57,877.4 | 45,665.0 |
| 41300 | Өглөг | 57,877.4 | 45,665.0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 7,368,817.3 | 3,304,206.1 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 7,368,817.3 | 3,312,899.0 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,899,045.4 | 462,549.0 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | - | 462,549.0 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,958,601.0 | 2,230,313.1 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,511,170.8 | 611,344.0 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 7,426,694.7 | 3,349,871.1 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 4,641,386.2 | 2,421,899.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 199,826.4 | 406,535.0 |
| 110 | Орлогын албан татвар | 66,966.9 | 235,241.2 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 66,966.9 | 235,241.2 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 97,762.2 | 140,458.3 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 35,097.3 | 30,835.5 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 754,509.9 | 403,155.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 754,509.9 | 403,155.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,687,049.9 | 1,612,209.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,751,275.0 | 1,469,218.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,751,275.0 | 1,469,218.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,571,258.7 | 1,449,146.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,988,443.8 | 429,189.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 260,571.3 | 52,088.0 |
| 2103 | Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал | 425,067.8 | 475,300.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 80,079.0 | 30,476.3 |
| 2105 | Нормативт зардал | 272,321.1 | 1,426.2 |
| 2106 | Эд хопшил, урсгал засварын зардал | 35,318.2 | 9,899.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,009.1 | 3,095.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 54,150.7 | 18,746.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 450,297.6 | 428,924.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 180,016.3 | 20,071.8 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 51,665.8 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 890,111.2 | 952,681.3 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 270,243.9 | 4,979,874.0 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 619,867.2 | -4,027,192.7 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,899,045.4 | 3,511,170.8 | 1,338,733.8 | 6,748,950.0 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,899,045.4 | 3,511,170.8 | 1,338,733.8 | 6,748,950.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 619,867.2 | 619,867.2 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,899,045.4 | 3,511,170.8 | 1,958,601.0 | 7,368,817.3 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,899,045.4 | 3,511,170.8 | 1,958,601.0 | 7,368,817.3 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -1,436,496.4 | -2,899,826.8 | 3,260,400.0 | -1,075,923.2 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 462,549.0 | 611,344.0 | 5,219,001.1 | 6,292,894.1 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | | | -4,027,192.7 | -4,027,192.7 |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 462,549.0 | 611,344.0 | 2,230,313.1 | 3,304,206.1 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 3,948,632.3 | 2,100,957.3 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 199,826.4 | 406,535.0 |
| 110 | Орлогын албан татвар | 66,966.9 | 235,241.2 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 66,966.9 | 235,241.2 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 97,762.2 | 140,458.3 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 35,097.3 | 30,835.5 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 5,074.1 | 2,192.7 |
| 1181 | Газрын төлбөр | 5,053.7 | 21,621.8 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 24,969.5 | 7,021.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 109,737.9 | 98,782.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 109,737.9 | 98,782.2 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,639,068.1 | 1,595,640.1 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,381,110.7 | 1,126,058.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,381,110.7 | 1,126,058.2 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,178,083.6 | 1,103,347.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,989,066.9 | 430,583.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 259,332.1 | 52,479.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 431,627.7 | 470,989.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 79,754.0 | 27,480.7 |
| 2105 | Нормативт зардал | 239,089.5 | 1,426.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 23,127.0 | 10,399.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,009.1 | 3,095.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 55,594.5 | 23,961.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,482.7 | 82,931.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 203,027.1 | 22,711.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 567,521.7 | 974,899.1 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 302,009.1 | 659,070.1 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 302,009.1 | 659,070.1 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 302,009.1 | 659,070.1 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -302,009.1 | -659,070.1 |
| VII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)=(III)+(VI)+(VII) | 190,512.6 | 315,829.0 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл | 300,485.2 | 490,997.7 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 490,997.7 | 806,826.8 |

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|--|--------------------|--------------------|------------------|-------------|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,933,237.2 | 1,560,465.6 | 372,771.6 | 80.7 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,169,884.1 | 1,079,827.1 | 90,057.0 | 92.3 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,147,393.0 | 1,059,755.3 | 87,637.7 | 92.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 443,965.1 | 428,483.8 | 15,481.3 | 96.5 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,044.0 | 52,416.0 | 2,628.0 | 95.2 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 518,232.7 | 470,989.9 | 47,242.8 | 90.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 28,694.4 | 25,641.5 | 3,052.9 | 89.4 |
| Нормативт зардал | 635.8 | 635.0 | 0.8 | 99.9 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 30,414.1 | 27,330.6 | 3,083.5 | 89.9 |
| Томиллолт, зочны зардал | 3,297.8 | 3,095.8 | 202.0 | 93.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,199.6 | 17,183.9 | 3,015.7 | 85.1 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 46,909.5 | 33,978.9 | 12,930.6 | 72.4 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 22,491.1 | 20,071.8 | 2,419.3 | 89.2 |
| Бусад урсгал шилжүүлэг | 22,491.1 | 20,071.8 | 2,419.3 | 89.2 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 635,037.9 | 480,638.5 | 154,399.4 | 75.7 |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 128,315.2 | - | 128,315.2 | 0.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,933,237.2 | 1,633,035.6 | 300,201.6 | 84.5 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,680,082.2 | 1,590,025.2 | 90,057.0 | 94.6 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 253,155.0 | 43,010.3 | 210,144.7 | 17.0 |
| Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эний үлдэгдэл | - | 209,854.4 | (209,854.4) | |
| Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 279,785.2 | (279,785.2) | |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-----------|--|------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 269,291.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 109,291.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 62,023.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 63.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,839.2 |
| 2105 | Нормативт зардал | 791.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,277.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,952.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 47,268.0 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 47,268.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 160,000.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 160,000.0 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 269,291.5 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 269,291.5 |

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхонтуул сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Дээд шатны байгууллагын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх өөрийн сумын онцлогт тохирсон бодлогыг боловсруулах, төрийн үйлчилгээг хэрэглэгчдээ шинэлэг хэлбэрээр хүртээмжтэй хүргэх”* гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд 2022 оныг *“Бүтээн байгуулалт, нийгмийн хөгжлийг дэмжих жил”* болгон зарлаж үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Аймгийн “Чанарыг эрхэмлэх жил”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах, үр дүнг тооцох,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,
- Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, хүлэмжийн болон зоорийн аж ахуй эрхлэлтийг дэмжих, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,
- Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг ханган “Хариуцлагатай уул уурхай”-г хөгжүүлж хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх,
- Санхүүгийн зөрчилгүй сум болж, орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлж ажиллах,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,*
- *Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- *Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагааг хамарч хяналт, шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхонтуул сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан *“Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”*-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхонтуул сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан *“Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,076,823.7 мянган төгрөгөөр буюу 54.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

СЭА-2023/09-НА-СТА-ТТЗ

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|---------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 490,997.7 | 806,826.8 | 315,829.1 |
| Авлага | 200,569.7 | 105,040.6 | -95,529.1 |
| Бараа материал | 239,463.5 | 28,779.3 | -210,684.2 |
| Үндсэн хөрөнгө | 6,495,663.8 | 2,409,224.4 | -4,086,439.4 |
| Нийт хөрөнгө | 7,426,694.7 | 3,349,871.1 | -4,076,823.6 |
| Өр төлбөр | 57,877.4 | 45,665.0 | -12,212.4 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 7,368,817.3 | 3,304,206.1 | -4,064,611.2 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 7,426,694.7 | 3,349,871.1 | -4,076,823.6 |

Эх сурвалж: Орхонтуул сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 806,826.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 315,829.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------|------------------|------------------|---------------------------|
| Банканд байгаа бэлэн мөнгө | 490,997.7 | 806,826.8 | 315,829.0 |
| Төгрөг | | | |
| Төрийн сангийн харилцах | 490,997.7 | 806,826.8 | 315,829.0 |
| Дүн | 490,997.7 | 806,826.8 | 315,829.0 |

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 482,567.2 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 162,051.6 мянган төгрөг / "Баянцогтын 2-р багт 105.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хүнсний ногооны зоорь барих ажил хийгдээгүй, зураг төсвийн зардал 28653.5 мянган төгрөг, гэрээний зөрүү 28398.1 мянган /, ХХС-ийн үлдэгдэл 117,733.6 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл 44,474.4 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 105,040.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 95,529.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------------|------------------|------------------|------------------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,584.9 | 600.0 | -984.9 |
| Зээлийн хүүгийн авлага | 6,578.2 | 4,200.3 | -2,377.8 |
| Байгууллагаас авах авлага | 53,811.5 | 578.7 | -53,232.8 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 4,591.3 | 4,906.8 | 315.5 |
| Зээлийн авлага | 134,003.9 | 94,754.7 | -39,249.1 |
| Дүн | 200,569.7 | 105,040.6 | -95,529.1 |

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэл 105,040,6 мянган төгрөг болж 95,529.1 мянган төгрөгөөр буурсан бөгөөд бүтцийн өөрчлөлтөөр 63,600.4 мянган төгрөгийн авлага холбогдох яамдын төсвийн ерөнхийлөн захирагчдад шилжсэн нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 54.9 хувь буюу 98,955.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Тайлант онд насжилт өндөртэй /7-оос дээш жил/ ХХС-ийн зээлийн авлагыг барагдуулахаар 10 иргэнтэй холбоотой 39,294.5 мянган төгрөгийн нэхэмжлэлийг холбогдох шатны шүүхэд хүргүүлсэн бөгөөд Шүүхийн шийдвэрийн дагуу 13,700.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ нь төлбөр тооцоог хянаагүйгээс ажилчидтай холбоотой 600.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- Захирагчийн алба нь төлбөр тооцоог хянаагүйгээс ажилчидтай холбоотой 1,540.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 28,779.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 210,684.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ | |
|----------------------------|------------------|-----------------|--------------------|-------------|
| | | | Өсөлт (+), | Бууралт (-) |
| Түүхий эд материал | 71,555.6 | 0.0 | | -71,555.6 |
| Эм боох материал | 71,555.6 | 0.0 | | -71,555.6 |
| Хангамжийн материал | 167,907.9 | 28,779.3 | | -139,128.6 |
| Бичиг хэргийн материал | 7,696.0 | 2,580.0 | | -5,116.0 |
| Аж ахуйн материал | 128,042.9 | 3,141.1 | | -124,901.9 |
| Сэлбэг хэрэгсэл | 1,620.0 | | | -1,620.0 |
| Хүнсний материал | 6,544.6 | | | -6,544.6 |
| Бусад хангамжийн материал | 24,004.4 | 23,058.2 | | -946.2 |
| Дүн | 239,463.5 | 28,779.3 | | -210,684.2 |

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 210,684.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 558,221.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 297,557.2 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэсэн болон 260,663.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллагуудын 210,684.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант оны эцэст ЗДТГ, ИТХ, Захирагчийн алба нь бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй,
- ЗДТГ нь 3,472.0 мянган төгрөгийн, Захирагчийн алба нь 3,865.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй,

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,409,224.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,086,439. мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |
|----------------------------------|--------------------|--------------------|------------------------|
| | | | Өсөлт (+), Бууралт (-) |
| Биет хөрөнгө | 7,929,905.5 | 3,367,514.3 | -4,562,391.2 |
| Барилга, байгууламж, орон сууц | 6,170,405.4 | 2,103,106.2 | -4,067,299.2 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 296,778.5 | 241,606.0 | -55,172.5 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 479,942.6 | 113,050.2 | -366,892.3 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 345,142.9 | 63,045.3 | -282,097.5 |
| Зам, гүүрийн байгууламж | 379,461.6 | 501,424.6 | 121,963.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 240,290.8 | 345,281.9 | 104,991.1 |
| Ном | 17,883.8 | 0.0 | -17,883.8 |
| Биет бус хөрөнгө | 148,775.4 | 9,962.0 | -138,813.4 |
| Программ хангамж | 9,675.0 | 5,150.0 | -4,525.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 139,100.4 | 4,812.0 | -134,288.4 |
| Дүн | 8,078,680.9 | 3,377,476.3 | -4,701,204.6 |

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос /анхны өртгөөр/ 4,701,204.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 18,431.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, замын сангийн хөрөнгө оруулалтаар 38,128.1 мянган төгрөгийн, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 369,924.9 мянган төгрөгийн ажил гүйцэтгэж, нийт 407,953.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн зэрэг 426,384.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллагуудын 5,127,589.2 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 45,664.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,212.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | / мянган төгрөгөөр / |
|-----------------------------|-----------------|-----------------|------------------------|
| | | | Өсөлт (+), Бууралт (-) |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 439.7 | | (439.7) |
| Байгууллагад төлөх өглөг | 57,412.7 | 45,334.9 | (12,077.8) |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 25.0 | 330.0 | 305.0 |
| Дүн | 57,877.4 | 45,664.9 | 12,212.5 |

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл буурахад бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллагуудын 28,821.2 мянган төгрөгийн өр төлбөрийг шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд байгаль орчны нөхөн сэргээх арга хэмжээний барьцааны 45,334.9 мянган төгрөгийн, ажиллагсадтай холбоотой шинээр үүссэн 330.0 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь төлбөр тооцоог хянаагүйгээс 330.0 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,304,206.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,064,611.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | / мянган төгрөгөөр / |
|---|---------------------|---------------------|------------------------|
| | | | Өсөлт (+), Бууралт (-) |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн | 1,899,045.40 | 462,549.00 | -1,436,496.40 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,958,601.00 | 2,230,313.10 | 271,712.00 |
| Өмнөх үеийн үр дүн | 1,338,733.80 | 6,257,505.80 | 4,918,772.00 |
| Тайлант үеийн үр дүн | 619,867.20 | -4,027,192.70 | -4,647,059.90 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,511,170.80 | 611,344.00 | -2,899,826.80 |
| Дүн | 7,368,817.30 | 3,304,206.10 | -4,064,611.20 |

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдлийн бууралтад тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

3.4.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 11,960.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын Тамгын газар:

СЭА-2023/09-НА-СТА-ТТЗ

- 2021 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгож, нэг удаагийн тэтгэмж авсан боловч хөдөлмөрийн гэрээгээр ЗДТГ-ын даргын үүрэг гүйцэтгэсэн Ш.Өнөрбаярт өндөр насны тэтгэвэрт гарсан гэх шалтгаанаар 6,273.9 мянган төгрөгийн тэтгэмжийг дахин олгосон,
- Нягтлан бодогч Б.Хоролсүрэнд улирлын үр дүнгийн урамшуулалд 1,196.5 мянган төгрөгийг давхардуулан олгосон.

Рашаант тосгоны Захирагчийн алба:

- Рашаант тосгоны захирагч Б.Отгонбаярын сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад оны эцэст 697.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

- Нутгийн удирдлагын 30 жилийн ойг тохиолдуулан спортын арга хэмжээ зохион байгуулж 811.5 мянган төгрөгийн зардал гаргасан,
- ИТХ-ын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтад хамруулахад 2,980.8 мянган төгрөгийн зардал гаргасан,

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Орхонтуул сумын ИТХ-ын “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 38 дугаар тогтоолоор тайлант онд 213,112.0 мянган төгрөгийн татварын орлого, 25,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 238,112.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 446,179.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 87.4 хувиар давуулан биелүүлсэн байна

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлтийн хувь |
|---|------------------|------------------|------------------|-----------------|
| Цалин хөлс түүнтэй адилтгах орлого | 122,000.0 | 183,727.8 | 61,727.8 | 150.6 |
| Хувь хүний орлогын албан татвар | 22,000.0 | 27,213.9 | 5,213.9 | 123.6 |
| Хөрөнгийн орлого | 22,000.0 | 20,243.5 | -1,756.5 | 92.0 |
| Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар | 5,000.0 | 4,056.0 | -944.0 | 81.1 |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 6,000.0 | 14,087.9 | 8,087.9 | 234.8 |
| Бууны албан татвар | 1,200.0 | 1,110.0 | -90.0 | 92.5 |
| Малд ногдуулах албан татвар | | 125,260.4 | 125,260.4 | |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1,700.0 | 950.7 | -749.3 | 55.9 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 225.0 | | -225.0 | |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 4,000.0 | 1,242.0 | -2,758.0 | 31.0 |
| Газрын төлбөр | 28,633.0 | 21,194.3 | -7,438.7 | 74.0 |
| Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж | 254.0 | 677.0 | 423.0 | 266.5 |
| Байгалийн ургамал ашигласны төлбөр | 100.0 | 6,344.0 | 6,244.0 | 634.4 |
| Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого | 10,000.0 | 7,791.0 | -2,209.0 | 77.9 |
| Хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого | 15,000.0 | 32,280.8 | 17,280.8 | 215.2 |
| Дүн | 238,112.0 | 448,179.3 | 208,067.3 | 187.4 |

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд цалин хөлс түүнтэй адилтгах орлого 61,727.8 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын орлого 5,213.9 мянган төгрөгөөр, ҮХЭХ-ийн албан татвар 8,087.9 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 423.0 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 6,244.0 мянган төгрөгөөр, бусад орлого 17,280.8 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Төлөвлөгдөөгүй байсан малд ногдуулах албан татвараар 125,260.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Хөрөнгийн орлого 1,756.5 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 944.0 мянган төгрөгөөр, бууны албан татвар 90.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 749.6 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 225.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2,758.0 мянган төгрөгөөр, газрын төлбөр 7,438.7 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 2,209.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Цалин хөлс түүнтэй адилтгах орлого:** Ажилчин албан хаагчдын цалингаас суутгасан ХХОАТ-ыг сумын орлогод төвлөрүүлдэг болсон,
- **ХХОАТ-ын орлого:** Малчдад олгосон ноолуурын урамшууллаас татвар суутгасан,

- **ҮХЭХ-ийн албан татвар:** Иргэдийн үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт, борлуулалт нэмэгдсэнээс,
- **Байгалийн ургамал ашигласны төлбөр:** Иргэд аж ахуйн нэгжид хадлангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэн олгосноос,
- **Бусад орлого:** Сумын нэр заагдаагүй орлогуудыг төвлөрүүлснээс,
- **Малд ногдуулах татвар:** Малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- **Хөрөнгийн орлого:** Иргэдийн хадгаламжийн орлого буурсан болон орлогын төлөвлөлтийг үндэслэл муутай тооцсоноос,
- **Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Хариуцсан албан тушаалтнууд айл өрх, иргэд, аж ахуйн нэгжүүдэд хяналт, шаардлага тавьж ажиллаагүйгээс,
- **Газрын төлбөр:** 2020 оны 11 дүгээр сараас газрын даамал газрын төлбөр төвлөрүүлдэг байсныг татварын цахим төлбөрийн системд холбосонтой холбоотойгоор буурсан,
- **Хүү, торгуулийн орлого:** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд торгуулийг цаг хугацаанд нь төлөөгүй зэргээс шалтгаалж орлогын төлөвлөгөө тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,453,401.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 27 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 258,112.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 968,418.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 442,382.9 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 221,707.7 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 130,000.0 мянган төгрөг нийт 2,021,120.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 38 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 20,000.0 мянган төгрөгөөр бууруулан 238,112.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 67,883.5 мянган төгрөгөөр бууруулан 900,534.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 442,382.9 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 221,707.7 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 130,000.0 мянган төгрөг зэрэг нийт 1,933,237.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, зарцуулахаар эцэслэн баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 446,179.3 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 442,382.9 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 500.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгээс 900,534.6 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 301,707.7 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 42,510.3 мянган төгрөг зэрэг нийт 2,133,814.8 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,560,465.6 мянган төгрөг буюу 80.7 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 15,481.3 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 2,628.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 47,242.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 3,052.9 мянган төгрөгөөр, нормативт зардал 0.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 3,083.5 мянган төгрөгөөр, томилолтын зардал 202.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 3,015.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 12,930.6 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 2,419.3 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 154,399.4 мянган төгрөг, эргэн төлөгдөх зээл 128,315.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 16 төсөл, арга хэмжээнд 635,037.9 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 480,638.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 162,051.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл хөтөлбөр хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн дээд шатны төсвийн захирагчаас 263,326.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 896.4 мянган төгрөг, ЗДНХ-өөс 5,068.3 мянган төгрөг зэрэг нийт 269,291.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2,163.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,839.3 мянган төгрөг, хоолны зардалд 791.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 8,277.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 48,952.6 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 47,268.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 160,000.0 мянган төгрөг зэрэг нийт 269,291.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхонтуул сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/54 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 3,739,271.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 56,089.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв зэрэг байгууллагууд нь тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал болох 1,560,465.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 23,406.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах,

аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Үүнээс Орхонтуул сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг 19.3 хувиар хэмнэсэн,
- Төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан аймгаас өгөх санхүүгийн дэмжлэгийг 67,883.5 мянган төгрөгөөр бууруулсан тул төсвийн тодотгол, зохицуулалтаар төсвийн зардлыг орлогын эх үүсвэртэй уялдуулан 87,883.5 мянган төгрөгөөр бууруулсан,

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн нийт 3,792.2 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Нутгийн удирдлагын 30 жилийн ойг тохиолдуулан спортын арга хэмжээ зохион байгуулж 811.5 мянган төгрөгийг зарцуулсан,
- ИТХ-ын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтад хамруулахад 2,980.8 мянган төгрөгийн зардал гаргасан,
- 2021 онд өндөр насны тэтгэвэрт гарч тэтгэмж авсан Тамгын газрын дарга Ш.Өнөрбаярыг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж 2022 оны эцэст өндөр насны тэтгэвэрт гарсан гэх үндэслэлээр дахин 6,273.9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон,

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

| д/д | Байгууллагын нэр | Мэдээлбэл зохих | Мэдээлсэн | Хугацаа хоцроосон | Мэдээлээгүй |
|-----|------------------------------|-----------------|------------|-------------------|-------------|
| 1 | Төсвийн төвлөрүүлэн захирагч | 155 | 95 | 55 | 5 |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 151 | 121 | 30 | |
| 3 | Засаг даргын Тамгын газар | 151 | 121 | 30 | |
| 4 | Захирагчийн алба | 151 | 121 | 30 | - |
| | Нийт дүн | 608 | 458 | 145 | 5 |

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 608 мэдээллээс 458 мэдээллийг хугацаанд нь, 145 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол огт мэдээлээгүй 5 мэдээлэл байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Илрүүлэлт: Орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй Баянцогт 2-р багт 25,200.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, мал угаалгын ванн барих, Хонгор овоо 3-р багт 14,600.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, малчдад үйлчлэх багийн байр засварлах, малчдад зориулсан сургалт сурталчилгааны 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах зэрэг нийт 59,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр төлөвлөж хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”: . 60.3.6 дахь “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 86 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.3.2 дэх “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Шийдвэрлэсэн нь: Иргэдийн саналаар дэмжигдсэн төсөл арга хэмжээг төсвийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлж байх зөвлөмж өгөв.

2.1 Илрүүлэлт: Орхонтуул суманд 2021 оны эцэст 225.1 мянган толгой мал тоологдсон боловч сумын төсвийн орлогын төлөвлөгөөнд малын тоо толгойн албан татварыг төлөвлөж тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сумын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.8.15: малын тоо толгойн албан татвар”, Малын тоо толгойн албан татварын тухай

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна”, 5.2 дахь “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2.Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн дагуу бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөлтийг хийж байх зөвлөмж өгөв.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар ЗДТГ-ын дарга Ш.Өнөрбаярт өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжид 3,782.6 мянган төгрөг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зэрэг 973.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, ур чадварын нэмэгдлийг зохих журмын дагуу олгоогүй, шатахуун зарцуулалтын тооцоог хийгээгүй, төлбөрийн цахим баримттай холбоотой 107,264.6 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах албан шаардлага, худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар | | Биелэлт | | |
|-----------------|----------------|------------------|----------|----------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 3,782.6 | 1 | 3,782.6 | 100.0 |
| Албан шаардлага | 2 | 973.5 | 1 | 973.5 | 50.0 |
| Зөвлөмж | 4 | 107,264.6 | 3 | 2,850.0 | 75.0 |
| Нийт дүн | 7 | 112,020.7 | 5 | 7,606.1 | 75.0 |

Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Өмнөх аудитаар өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг Тамгын газрын дарга Ш.Өнөрбаярт илүү олгож, төлбөрийн актыг бүрэн барагдуулсан боловч тайлант онд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж, тэтгэвэрт гарсан гэх үндэслэлээр дахин 6,273.9 мянган төгрөгийн тэтгэмж өгч, зөрчлийг давтан гаргасан байна.

Иймээс Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй..... **албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно**” гэсэн заалтыг үндэслэн зөрчлийг давтан гаргасан сумын Засаг дарга П.Батбаатар, өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн ханган ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй болон төсвийн гүйцэтгэлд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй Санхүүгийн албаны дарга С.Эрдэнэчимэг, ЗДТГ-ын нягтлан бодогч Б. Хоролсүрэн нарт **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

1.Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Б/29 дүгээр захирамжаар 2021 оны санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр сумын Санхүүгийн албаны дарга С.Эрдэнэчимэгт үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгох шийдвэрийг үндэслэн 1,386.6 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудит болон бусад аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

3.Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн авлагад 98,955.5 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 2011-2015 онд олгосон 17 иргэний 49,814,6 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг холбогдох шатны шүүхэд хандаж бүрэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

4. Байгууллагын хэрэгцээт бараа материалыг худалдан авахдаа хувь хүний нэр дээр цахим баримт авч, төлбөр тооцоог гүйцэтгэсэн тохиолдол гарч байгаа зөрчлийг арилгах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 86,667.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 2,922.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

- ✓ Үндсэн хөрөнгийн орлогын бүртгэл нь нягтлан бодох бүртгэлийн журналын дүнгээс зөрүүтэй тайлагнагдсан: Үүнд:
 - ЗДТГ 14,400.0 мянган төгрөг,
 - Захирагчийн алба 72,267.7 мянган төгрөг.

Залруулаагүй алдаа:

- ✓ Бусад үндсэн хөрөнгийн дансанд 2,922.6 мянган төгрөгийн өртөгтэй компьютер, техник хэрэгслийг бүртгэсэн байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д” Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төстэй шинж төрөл, чиг үүрэгтэй бөгөөд санхүүгийн тайланд толилуулах зорилгоор нэг ганц зүйл байдлаар харуулдаг хөрөнгүүдийн бүлэг юм” гэж тодорхойлсон заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэлт: 2023 оны эхний хагас жилд багтаан залруулгыг хийж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

Аудитаар нийт **84,202.6** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **6,971.2** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **14,508.8** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **62,722.6** мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 2021 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгож, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг авсан сумын ЗДТГ-ын дарга Ш.Өнөрбаярыг тайлант онд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж, өндөр насны тэтгэвэрт гарсан гэх үндэслэлээр дахин **6,273.9** мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтууд болон Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.2 дахь “...төрийн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджаас ихгүй байна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн сумын Засаг дарга П.Батбаатарт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, давхардуулан олгосон тэтгэмжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох, СЭА-2023/09-НА-СТА-ТТЗ

5.1.2 Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад Рашаант тосгоны захирагч Б.Отгонбаярт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал гэж 697.3 мянган төгрөг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дэх “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.1 дэх “...ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага:

ИТХ:

5.2.1 Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн нийт 3,792.3 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Нутгийн удирдлагын байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн хүрээнд спортын арга хэмжээ зохион байгуулж 811.5 мянган төгрөгийг зарцуулсан ,
- ИТХ-ын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтад хамруулахад 2,980.8 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор **байгууллага, хамт олныг сурталчлах**, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.2: “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс дараах байгууллага нь авлага, өр төлбөр үүсгэсэн нийт 2,470.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Сумын ЗДТГ нь төлбөр тооцоог хянаагүйгээс ажилчидтай холбоотой 600.0 мянган төгрөгийн авлага, 330.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- ИТХ нь цалингийн урьдчилгааг суутгаагүйгээс 1,540.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.3 Сумын ЗДТГ, Захирагчийн алба, ИТХ нь жилийн эцэст бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.2 дахь *“Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”* 12.2.1-д *“жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, 20 дугаар зүйлийн 20.2.6. дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ...”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хийж гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.4 ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Хоролсүрэнд ЗДТГ-ын даргын 2022 оны 9 сарын 21-ний өдрийн Б/28 дугаар тушаалаар санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэх үндэслэлээр 1,196.5 мянган төгрөг, жилийн эцэст улирлын ажлын үр дүнгийн урамшуулал 989.1 мянган төгрөг зэрэг нийт 2,185.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь тогтоосон хэмжээнээс 909.3 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар баталсан *“Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.5 Дараах байгууллагууд өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **7,337.0** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- ЗДТГ 3,472.0 мянган төгрөг,
- Захирагчийн алба 3,865.0 мянган төгрөг.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | /мянган төгрөгөөр/ Үүнээс | | | | Зөвлөмж | |
|------------------|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------------------------|-----------------|--------------|----------------|----------|----------------|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 2 | 17,322.6 | | | 1 | 14,400.0 | 1 | 14,400.0 | 1 | 2,922.6 | 1 | 2,922.6 |
| Захирагчийн алба | 1 | 72,267.7 | | | 1 | 72,267.7 | 1 | 72,267.7 | | | | |
| Дүн | 3 | 89,590.3 | | | 2 | 86,667.7 | 2 | 86,667.7 | 1 | 2,922.6 | 1 | 2,922.6 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|------------------|-------------|-----------------|---------------|----------------|-----------------|-----------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ЗДТГ | 1 | 6,273.9 | 1 | 6,273.9 | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | 930.0 | | | 1 | 930.0 | | | | | | |
| ЗДТГ | 1 | 909.3 | | | 1 | 909.3 | | | | | | |
| ЗДТГ | 1 | 3,472.0 | | | 1 | 3,472.0 | | | | | | |
| Захирагчийн алба | 1 | 697.3 | 1 | 697.3 | | | | | | | | |
| ИТХ | 1 | 3,792.3 | | | 1 | 3,792.3 | | | | | | |
| ИТХ | 1 | 1,540.0 | | | 1 | 1,540.0 | | | | | | |
| ИТХ | 1 | 3,865.0 | | | 1 | 3,865.0 | | | | | | |
| Дүн | 8 | 21,479.8 | 2 | 6,971.2 | 6 | 14,508.6 | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|
| | | | | | | | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроосон | 145 | | | | 145 | | | |
| Огт мэдээлээгүй | 5 | | | | 5 | | | |
| Дүн | 150 | | | | 150 | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | 59,800.0 | | | | | 1 | 59,800.0 |
| ТТЗ | 1 | | | | 1 | | | |
| Дүн | | | | | | | 1 | |
| Нийт дүн | 2 | 59,800.0 | | | | | 1 | 59,800.0 |